



ХУШААТ СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-07-30 № СА-2020/04-Н-В  
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Хушаат сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Хушаат сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


## Дүгнэлт

Хушаат сумын Ардчилсан намын хорооны Хушаат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хушаат сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр  
/....Э... хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Хушаат сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**УРИА: ӨРХИЙН ӨСӨЛТӨӨС ХУШААТЫН ХӨГЖИЛ**

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож:

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах, хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан АРДЧИЛСАН

НАМЫН СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН ХОРОО 2020-2024 оны ХУШААТ СУМЫН ИТХ-ЫН сонгуульд оролцох “**ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО**” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

**Нэг. Хувь хүн, нийгмийн хөгжил, эрх чөлөө**

**1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол**

- 1.1.1. Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ.
- 1.1.2. Амьжиргааны түвшин доогуур өрхийн болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд гадаад, дотоодын их дээд сургуульд суралцахыг дэмжиж, шилдэг суралцагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 1.1.3. Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.1.4. Сэлэнгэ аймгийн Хушаат сумын хүүхэд залуучуудыг гадаад хэлний боловсрол олгох сургалтад үе шаттай хамруулна.
- 1.1.5. Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.1.6. Иргэдийн цахим боловсролыг дэмжих клуб байгуулахыг дэмжиж иргэд олон улсын хэмжээний цахим сургалт, сурталчилгаа, мэдээллийг хувийн амьдралдаа ашиглаж чаддаг болохыг дэмжиж ажиллана.

**1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ**

- 1.1.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулна.
- 1.1.2. Сумын Эрүүл мэндийн байгууллагын тусlamж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.

- 1.1.3. Сэлэнгэ аймгийн Хушаат сумын хэмжээнд эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлэн Ар могой, Асмалжин рашааныг түшиглэн байгалийн үзэсгэлэнт газарт хувийн хөрөнгө оруулалтаар сувиллын барилга, байгууламжийг барих ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.1.4. Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд жил бүр хамруулна.
- 1.1.5. Эмнэлгийн түргэн тусlamжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчлэн материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг оновчтой зохион байгуулж, үр дүнг тооцдог болгоно.
- 1.1.6. Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг төрийн өмчийн болон хувийн эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.7. Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төрийн бодлогыг Хушаат сумандаа хэрэгжүүлнэ.
- 1.1.8. Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, дэрвэгэр жиргэрүү зэрэг ховор ургамлыг тарималжуулах, үржүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 1.1.9. Эмийн хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.
- 1.1.10. Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтворт суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, бодлогоор дэмжинэ.

### **1.3.Хүн амын өсөлт, хөгжил**

- 1.3.1. Сумын төвд хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.3.2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлэгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 1.3.3. Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүл – нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлж, өрх толгойлсон эх /ганц бие эцэг/, хүүхдийг эрсдэлээс хамгаалах нөхцөлийг сайжруулна.

### **1.4.Ажлын байр хөдөлмөр эрхлэлт**

- 1.4.1 Сумын иргэдийн гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (хувийн хэвшлийн хэрэгцээтэй нягт уялдуулан санхүүжилтийг зохион байгуулах, сургалт, мэдээллээр хангах, г.м.)-ийг бүрдүүлнэ.
- 1.6.3 Гарааны бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгч зорилтот бүлгийн иргэдийн гарааны санхүүжилтэд тавигдах шаардлагыг хөнгөлнө.


### **1.5.Нийгмийн хамгаалал**

- 1.5.1. Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлж , халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлнэ.
- 1.5.2. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.
- 1.5.3. Ахмадын сувиллууд байгуулах нөхцөл боломжийг сайжруулж, ахмадын сувиллыг байгуулахад хувийн хэвшлийн үүсгэл санаачилгыг дэмжинэ.

## **1.6. Соёл, урлаг, спорт**

- 1.6.1. Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын буртгэл, хамгаалалтыг сайжруулна. Хушаат сумын иргэд олон улсын тэмцээн, уралдаанд оролцохыг дэмжиж, олон нийтийн хандив, тусlamжийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.2. Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

## **Хоёр. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**



### **2.1. Хямралыг боломж, боломжийг өсөлт**

Ажлын байрыг хадгалж, иргэн, бизнесээ дэмжсэн сумын богино хугацааны тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.1.1. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг өргөнөөр хэрэглэх журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.1.2. Хушаат сумын хэмжээнд “Танаас худалдан авъя” хөдөлгөөнийг өрнүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ.
- 2.1.3. Үр тариа, төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд борлуулахад дэмжиж ажиллана.
- 2.1.4. Мал амьтны өвөлжилтөд онцгой анхаарч өвс тэжээлийн хомсдолоос сэргийлэн боломжит тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
- 2.1.5. Эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын тогтвортой ажиллах нөхцөл боломжийг хангаж ажиллана.

### **2.2. Өсөлтийн бодлого**

- 2.2.1 Сумандаа хуулийн засаглалын зөв механизмыг бүрдүүлж ажиллана.
- 2.2.2 Газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг санаачлан 100-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгох гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

### **2.3. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа**

- 2.3.1 Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.
- 2.3.2 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийг бүх талаар дэмжинэ.
- 2.3.3 Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөх үйлчилгээг сайжруулна.

### **2.4. Төсөв, санхүү, татварын бодлого**

- 2.4.1 Сумын төсвийн зарлагын гүйцэтгэлд хяналт тавьж төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нөөц орлогыг илрүүлэн орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 2.4.2 Түрээсийн орон сууц барьж, ашиглалтад оруулсан аж ахуйн нэгж, иргэнд байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал, ус ашигласны төлбөрөөс хөнтөлөх асуудлыг холбогдох байгууллагад уламжилна.

## 2.5. Хөдөлмөрийн зах зээл

- 2.5.1 Хушаат сумын хэмжээнд ядуурлын түвшинг улсын дунджаас бууруулах<sup>209</sup> бодлого хэрэгжүүлнэ.. /2020 оны улсын дундаж түвшин 28%, Сэлэнгэ аймаг 34,5%.  
МОА0065 9055436
- 2.5.2 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.5.3 Хушаат суманд дотоод гадаадын жуулчид хүлээн авах хүчин чадлыг өсгөж, аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлэн аялал жуулчлал дагасан үйлчилгээний тоо, хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.5.4 Хушаат сумын иргэн мэргэжилтэй ажиллах хүчин, боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургууль төгсөгчдийг үе шаттайгаар ажлын байраар хангах зорилгоор тус суманд ажилладаг төрийн болон хувийн өмчийн аж ахуйн нэгж, бусад байгууллагуудтай хамтран ажиллана.

## 2.6. Төрөлжилтийн бодлого

### 2.6.1. Үйлдвэрлэл

- 2.6.1.1 Зах зээлд өрсөлдөх чадвар бүхий түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.6.1.2 Хүнсний бүтээгдэхүүний лабораторийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага болон хувийн хэвшил байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 2.6.1.3 Орон нутагтаа стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох жимс жимсгэнэ, элсэн чихэр, ургамлын тосны хангамжийг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн үйлдвэр байгуулах санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.
- 2.6.1.4 Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хөнгөлөлттэй зээл, урамшууллын бодлогоор дэмжинэ.
- 2.6.1.5 Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.6.1.6 Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

### 2.6.2. Дэд бүтэц, барилга

- 26.2.1 Хушаат сумын төвөөс Дархан-Сэлэнгийн төв замд холбогдох 20,8 км урттай хатуу хучилттай засмал зам бариулах нөхцөлийг бий болгоход тус тойроос УИХ-ын гишүүнд сонгогдсон гишүүдийн дэмжлэгийг авч ажиллана.

2.6.2.2 Хушаат сумын нутаг дэвсгэр дээрх авто замын болон аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээний танилцуулга гарган маршрутыг тогтоон баталгаажуулна.

2.6.2.3 Шинэ суурьшлын бус болон сумын төвийн шинэчлэлийн хурээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг барьж байгуулах төслийг дэмжинэ.

### **2.6.3. Аялал жуучлал**

2.6.3.1 Спортын, эрүүл мэндийн, эко-туризм, ургамал, амьтан судлал, түүх соёлын дурсгалт газруудын судалгаа шинжилгээ экстрим /адал явдалт/ аялал зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.

2.6.3.2 Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжин морин болон усан аяллын шинэ маршрут бий болгон хөгжүүлнэ..

2.6.3.3 Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогод тусгагдсан байгалийн онцгой үзэсгэлэнт газар, тусгай хамгаалалттай газруудад хэрэгжих олон улсын байгууллагын болон хувийн хэвшлийн санаачилга хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдийг бодлогоор дэмжинэ.

### **2.6.4. Технологи, мэдээлэл, харилцаа**

2.6.4.1 Айл өрхийн хаягжилтыг сайжруулан шуудан хүргэлтийн системийг боловсронгуй болгож түгээлтийг нэмэгдүүлнэ.

2.6.4.2 Багш нар болон төрийн бусад албан хаагчдыг цахим боловсролын ур чадвар сайжруулах хөтөлбөрт хамруулна.

### **2.6.5. Эрчим хүч**

2.6.5.1 Хушаат сумын дулааны шугам сүлжээг шинэчилж хүчин чадлыг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

2.6.5.2 Гэр хорооплыг эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбох хувийн хэвшлийн байгууллагын төслийг дэмжин хэрэгжүүлнэ.

2.6.5.3 Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангах бодлого хэрэгжүүлнэ.

## **Гурав. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**

### **3.1. Орон нутгийн хөгжил**

3.1.1 Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын тодорхой хувийг орон нутагт нь шуд хуваарилах асуудлыг тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүдэд уламжилна.

3.1.2 Орон нутгийн худалдан авалтын үйл ажиллагааг сумандаа сонгон шалгаруулдаг, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг, шалгарсан байгууллагууд тухайн орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах бодлого баримталж ажиллана.

3.1.3 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.

- 3.1.4 Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлнэ.
- 3.1.5 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хүлэмжээр хангаж, иргэдийн орлого, мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.1.6 Ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн суурин хөгжүүлэхэд чиглэсэн төслүүдийг дэмжинэ. Сумын **ШИНЭЧЛЭЛИЙГ ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ “ШИНЭ СУМ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛНЭ.**
- 3.1.7 Иргэдэд зориулсан цахим боловсролын хувийн хэвшлийн клуб байгуулах иргэдийн санаачилгыг дэмжинэ.

### **3.2. Бэлчээр ашиглалт**

- 3.2.1 Бэлчээрийн татварын орлогыг тухайн орон нутгийн төсвөөр дамжуулан бэлчээрийн нөхөн сэргээлтэд зарцуулах тухай саналыг уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.2.2 Сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагжуулах журам баталж, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.2.3 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан сумын газар нутаг, бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн сэргээхэд бэлчээрийн татвараас бүрдсэн эх үүсвэрийг ашиглана.
- 3.2.4 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг сайжруулна.
- 3.2.5 Сумын хэмжээнд ашиглагдаагүй, ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож дэд бүтэц, усан хангамжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 3.2.6 Малыг тооноос чанарт шилжүүлэх, бэлчээрийн даацыг тохируулж, хамгаалж, сууринmallagaаны хэлбэрт шилжүүлэн сайжруулсан малчин өрх, бүлэг, хэсгийг дэмжиж ажиллана.

### **3.3. Газар тариалан**

- 3.3.1 Өндөр ашиг шимт, эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.3.2 Мал амьтны тэжээлийн үйлдвэрлэлийг бий болгоход бодлогоор дэмжинэ.
- 3.3.3 Өвлийн хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжин, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоогоор жилийн турш хангах зорилт тавин ажиллана.
- 3.3.4 Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж чанартай, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, сумын брэнд бүтээгдэхүүн бий болгох бодлого хэрэгжүүлнэ.

### **3.4. Мал аж ахуй**

- 3.4.1 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацид суурилж, хөгжүүлэн малчдыг малчин бизнесмен болго замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхарыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ. Хушаат суманд

Казакийн цагаан толгойт үүлдрийн үхэр сүрэг, Баяд удмын хонин сүргийг Хушаат сумын БРЭНД бүтээгдэхүүн болгон хөгжүүлнэ.

- 3.4.2 Арьс шир, түүхий эдийг анхан шатанд нь боловсруулах дамжлагыг ЖДУ-ийн бодлогоор дэмжин дотоод гадаадын үйлдвэрт нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллана.

### Дөрөв. ХАРИУЦЛАГАТАЙ ХУШААТЧУУД

- 4.1 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалтны ёс зүй, зан харилцаанд тавих олон нийтийн хяналтыг бий болгоно.
- 4.2 Малын хулгайгаас сэргийлэх, цахимаар хянаж хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж ажиллана.
- 4.3 Иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан тодорхой асуудлыг хөндөж, дэвшүүлсэн бол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шууд авч хэлэлцдэг болно.
- 4.4 Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан улирал бүр иргэдэд иргэний танхимд болон цахимаар ажлын тайлангийн сонсгол хийх журамд шилжинэ.
- 4.5 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
- 4.6 Төсвийн зарцуулалтад тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоо, хяналтын боломжуудыг бодитоор хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 4.7 Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод нээлттэй, иргэдийн хяналтын системийг бий болгоно.

### Тав. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ХУШААТЧУУД

- 5.1 Соёлын биет болон биет бус өвийг сумын баялагт тооцож, холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, үрэгдэж гэмтэх, гадагш алдагдахаас хамгаална..
- 5.2 Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдэхэд анхаарч ажиллана.
- 5.3 Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгтэй мэдлэг мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.

### ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

- 6.1 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлж, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.2 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагааг шат дараатай авч хэрэгжүүлнэ.
- 6.3 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

6.4 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин ажиллана.

6.5 Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийн бодлогыг баримталж ажиллан, айл өрх бүрийг жимс жимсгэний бут тариалахыг бодлогоор дэмжинэ.

